

Уул овоо тахих зан үйлийн нутаг нутгийн онцлог
(Ламын гэгээн шавийн жишээн дээр)

Хангай дэлхий, уул ус, байгалийн элдэв үзэгдэл юмс цаанаа эзэнтэй хэмээн үзэж, байгалийг шүтэх сүсэг бишрэл нь монголчуудын эртний цалиг шүтлэг, сүлд шүтлэг, онгон шүтлэгт тусгалаа олж нийлэгжсээр Чингисийн эзэнт гүрний үед “*Этүгэн эх, Мөнх тэнгэр*”-ийг шүтэх бөө мөргөлийн ёсонд дээд илэрлээ олжээ [122.1998.44].

Бурханы шашинд басхүү уул ус, газар нутаг, өвс ургамал цөм нүднээ үл үзэгдэгч лус, савдаг хэмээх хийбод эзэнтэй хэмээн үзэж, тэрхүү лус, савдгууд хүмүүний аж төрөл, хувь тавиланд ямар эерэг, сөрөг нөлөө үзүүлж болохыг зааж номлож ирсэн байна. “Буман цагаан лус” нэртэй сударт “*лус*” хэмээх нь *усанд*, “*савдаг*” хэмээх нь *газарт*, *хүчир догшин “няан” (нян) хэмээх нь огторгуйд оришино* гэжээ. Эдгээр нь өөрсдийн эзэмшдэг уул хангай, ус, агаар, ан амьтан, эрдэс баялагтай зүй бусаар харьцвал хилэгнэн догширч, үер ус, ган, зуд нүүрлүүлэх төдийгүй харьяалан захирдаг олон зүйл ад, зэтгэр тэргүүтнийг илгээн цаг бусын аюул, үхэл зовлон, өвчин тахал, гай гамшгийг өдөөдөг хэмээн үздэж иржээ. Иймээс ч ган зуд болох, хур бороо цагтаа эс буух, үр тарианы ургац үл боловсрох зэрэг байгалиас хамаарах гамшиг тохиолдох үед лус савдаг аргадах зан үйлийг үйлдэж иржээ.

“*Тахил өргөх*”, “*тахих*”, “*тайх*”, “*тайлга хийх*” хэмээхүй нь хэлний талаасаа үгийн язгуур нэгтэй ч тухайн уул хайрхан, тахилга шүтээний учир холбогдол, түүх уламжлал, өргөмжлөл хүндлэлийн цар хүрээнээс хамааралтай өөр өөр түвшний нэр томьёо юм.

- *Тахил өргөх* нь шүтлэгийн нэн эртнээс улбаатай зан үйлийн зэрэгцээ сүсэг бишрэл гэхээсээ ардын ёс заншил, амьдралын хэвшил гэхээр болж үеэс үед уламжлагдсан түгээмэл зан үйл
- *Тахих* хэмээх нь гэр бүл, отог овог, нутаг нугын хүрээнд зохиогддог шашин, соёлын багц зан үйл
- *Тайх* хэмээх нь овог аймаг, ястан угсаатан, улс үндэстний хэмжээнд ёслол тэмдэглэж ирсэн төр, шашны ёслол хүндэтгэлийн цогц зан үйл гэж ойлгож болно.
- *Тайлга* гэдэг нь уул овоог тахиж тайсны дараа хийх тайлгын ёслол болно

Тахилын зан үйлийн хамгийн энгүүн жишээ нь цацал өргөх ардын ёс заншил юм. Монголчууд сүү, цайныхаа дээжийг тэнгэр хангай, уул усанд есөн нүдэт цацлаар цацал өргөн мялаахдаа:

“*Сайн зүгийн минь тэнгэр*
Саруул зүгийн минь заяа
Буусан нутаг
Суусан хангай минь
Гарахын гарзыг хааж
Орохын олзыг нээж хайрла аа”

“Төрийн минь сүлд

Түмний минь сахиус өршөөж хайрла аа”

“Хол ойр яваа хүүхдүүдийн минь заяа, замыг тэгшилж хайрла аа” гэх мэтчлэн өөр, өөрт холбогдолтой сэдвээр ажил үйлс, аз хийморь алив бүхнээ даатган шүлэглэдэг. Монголчууд өдөр тутмынхаа ахуй амьдралд энэ мэт зан үйл, аман билгийн холбогдолтой ерөөл билиг, тахил мялаалгын үгийг өргөн хэрэглэж ирснийг илтгэх өөр нэг жишээ нь

- Архи сархадын дээжийг сөгнөн барихуйд:

“Гал голомт тань гал бадраан амгалан болтугай

Хангай дэлхийтэйгээ хамтдаа амгалан болтугай

Төрийн сүлд өршөөж, түмэн олноороо амгалан болтугай” хэмээн сэржим өргөнө.

- Төрсөн газар, хүй дарсан тоонотдоо очихдоо:

“Унасан газар

Угаасан ус

Төрсөн нутаг

Төгрөг буудал

Урдаас угтаж

Хойноос хардаг

Уул ус минь” гэх зэргээр уяран сүслэж тахилга, мялаалга өргөдөг.

- Овооны дэргэдүүр гарсан хэн боловч унаанаасаа бууж, уг овоог гурав тойрон гороолж:

“Овооны их нь таньд

Олзны их нь маньд

Өлийн их нь таньд

Өлзийн их нь маньд

Сүрийн их нь таньд

Сүлдний их нь маньд” хэмээн хэлж, чулуу нэмдэг заншилтай.

Аман билгийн энэ мэт ерөөл, мялаалга, өчил залбирал нь хүн зонд байгаль хамгаалах дадал хүмүүжил олгох үр нөлөөтэй арга хэрэгслэл болсоор иржээ. Энэ тухай их сэтгэгч Богд Зонхов “Бодь мөрийн зэрэг” хэмээх суурь бүтээлдээ *“Залбиран мөргөх, бахдан баясах, гуйж хүсэх, сүслэн даатгах зан үйл нь хүнд сайн чанар бүрдүүлэх, өөрийн зөв дадлаа бататган арвитгах шалтгаан болно”* хэмээн айлдсан байна.

Монгол нутгийн уул нуруу, сүрлэг сүмбэр оргил бүр тухайлан зориулсан магтаалтай бөгөөд монголчууд “Алтайн магтаал”, “Хангай ханы магтаал”, “Богд Дүнжингаравын магтаал”, “Их Богдын магтаал”, “Хан Хөхийн магтаал” зэрэг аман билгийн томоохон төрлийг бүтээн туурвиж түүгээрээ тус тусын уул, хайрханд мялаалга өргөн газар лусыг баясгаж иржээ

Говь түшээ гүний хошууны алдарт ерөөлч Гэлэгбалсан ган гачиг тохиолдсон нутагт хошуу алгасан залагдаж “Тэнгэрээс бороо хур гуйх ерөөл” айлдан, хур бороотой залгуулж явсан түүх¹ үүнийг нотломуй.

¹ Чимэд.Ө. Ерөөлч Гэлэгбалсан. УБ. 1956

Баруун монголын туульч нар тууль хайлахдаа эхлээд заавал “Алтайн магтаал” хэлж, Алтайн эзэн Алиа Хонгорыг урин залж, арц умлуулж, цацал өргүүлэн байж, Алтайн эзэн, савдаг шивдэг, лус найман аймгийг цэнгүүлдэг ёс уламжлалтай бөлгөө.

Монгол даяар түгээмэл тэмдэглэн ёсолдог уул овооны сан тахилга нь Бурхад, дошгидыг урин залаад тэдний өмнө тухайн орон газрын эзэн тэнгэр, лус савдагийг номын хүчээр дуудан залж ирүүлээд, идээ, умдаан, элдэв тахилын зүйлээр дайлж, цайлан баясгаж, тухайн орон газрыг ган зуд, гал усны аюул хийгээд лус савдагийн хорлолгүй амар амгалан байлгаж, хэн хэндээ нөхөр болж, эв найртай орших захиа даалгаврыг бурхан сахиулснуудаар өгүүлж, ам өчгийг авахуулж буй утга чанартай шашны зан үйл юм.

Тахилгын зан үйлийн гол цөм болсон бурханы шашны сангийн судар, бөө мөргөлийн дуудлага, тамлага нь аман болон бичгийн хэлний яруу зохист хэл найруулгатай яруу найргийн бие даасан хэлбэр байдгаараа монголчуудын утга соёл, аман өвийн чухал дурсгал болно.

Монголчууд хангай дэлхий, уул овоондоо сүү, идээгээр төдийгүй дуу, хөгжмөөр мялаалга өргөж, энэ нь эргээд ач буянаа хайрладаг гэдэгт итгэн сүсэлдэг. Тухайлбал, Өвөрхангай нутагт “Өндөр хангайн оргил” хэмээх дууг өндөр уулан дээр гараад дуулахад алдуул эрэл олддог, “Зээтэй өндөр хангай”-г аянд явсан хүн нутгийн бараа хараад дуулдаг, “Ар хөвч”-ийг дуулахад “адуу өсдөг, айраг исдэг” гэлцэх². Тэрчлэн нутаг, нутгийн уул овооны тахилга, тайлгад тухайлсан зориулалтын дуугаар ая өргөдөг уламжлал буй. Жишээ татваас: Отгонтэнгэр уулыг тайхад “Оройн чимэг” хэмээх дууг, Хангай хайрхан овооны тахилгад “Өндөр хангай” хэмээх дууг дуулдаг заншилтай. Цуур, бүрээ, бишгүүр, лавайн эгшгээр уул, ус, тэнгэр хангайд ая (нянсан) өргөж лус, савдагийг баясгах, аргадах, ангийн хишиг гуйх тэргүүтэн зан үйлийг гүйцэтгэж байсан жишээ цөөнгүй.

Уул, овоо, онгод шүтээнээ тахисны дараа тайлга хийж найр, наадам үүсгэдэг уламжлал нэн эртний гаралтай юм. Тайлгын зан үйлийн чухал бүрэлдүүн хэсэг нь уул усны эзэд, лусыг баярлуулан цэнгүүлэхэд чиглэсэн эрийн гурван наадам болно. Наадмаар:

1. амирлуулахуй
2. Дэлгэрүүлэхүй
3. Эрхэндээ хураахуй
4. Хариулах буцаахуй

гэсэн бурханы сургаалын дөрвөн төрлийн үйлийг бэлгэшээн үйлдэнэ. Үүнд:

- дуу, хуурын яруу эгшгээр *амирлуулах* үйлийг
- хүчит бөхийн барилдаанаар *эрхэнд хураах* үйлийг
- хурдан морины уралдаанаар *дэлгэрүүлэх* үйлийг
- нум, сум харвах тэргүүтнээр *хариулах* буцаах хатуу үйлийг бурхад дошгид, уул усны эздэд даатган өргөдөг уламжлалтай ажээ.

Монголчуудын байгаль хамгаалах үзэл, хүмүүжлийн хамгийн тод илрэл болсон уул, ус тахих монгол зан үйл бол нүүдэлчин монголчуудын энэрэл хүндэтгэлийн уламжлал,

² Хүрэлбаатар.Л. Дуун утгын яруу зохист. УБ, 2005

хорио цээрийн уламжлал, сургаал номлолын уламжлал, сүсэг бишрэлийн уламжлал, ажиглалт танин мэдэхүйн уламжлалын цогц юм.

Ламын гэгээн шавь нь бүх нийтээр тахидаг; дацан бүр тусдаа тахидаг; ах дүүс, нутаг усаараа нийлж тахидаг; гэгээн сангийн сүрэгчид тахидаг; Лиг цагаан голын тариачин өрхүүд тахидаг; өртөө улааны алба гүйцэтгэхээр гаднын хошуудаас ирсэн өртөөчид тахидаг гэх мэт тус тусын онцлогтой, их бага тахилга бүхий 33 уул овоо, 17 ус булаг байсныг нутгийн хуучуул дурсан ярьдаг³.

Шавь нийтээр Их Богд уул, мөн Сэгс цагаан Богд уулыг тахиж байжээ. Монгол Алтайн их уулсын цуваанд Цамбагарав уул Цагаан тэнгэр нь, Гаарийгарав (Цаст цагаан уул) буюу Их Богд уул орд өргөө нь, Орог нуур цөгцтэй цай нь гэсэн домог ч буй. Тэрчлэн Говийн Их Богд уул, Их хүрээний өмнөх Богд Дүнжингарав уул (Цагаан лавай тэтгэгч уул), хээрийн бүсийн Богд уул (Хүрээмарал, Бууцагаан сумын нутгийн заагт орших) дундаа нэг савдагтай гэж үздэг байжээ. Дундын савдаг нь Хангарди. Хээрийн бүсийн Богд уулыг “Өврийн багш” хэмээн олноо алдаршсан Жамбалзундуй ламтан 1930-аад оны эхээр очиж тахихдаа товлосон өдрөө тахисангүй, маргааш нь тахижээ. Учир нь уг товлосон өдөр Их хүрээнээс Богд Дүнжингарав уулыг тахиж байсан тул савдаг нь эзгүй байгаа гэж үзсэн ажээ.

Их Богд уулын Латааны овоог хамгийн сүүлд 1937 онд сүүлчийн майдарын жил тахиснаас хойш уг зан үйл 52 жил тасалдаад, 1989 оны зун дахин сэргэсэн ба 2004 онд Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор Их Богд уулыг Баянхонгор аймгийн “Сүлд уул” болгон тахих шийдвэр гаргаж, хоёр жил тутамд тахих болжээ.

Ламын гэгээний хүрээнээс уул, овоог төдийгүй ус, рашааныг тахиж байсны жишээ нь Шаргалжуутын рашааны тахилга, тайлга юм. Энэ рашаанд Заяын гэгээн, Ламын гэгээнтний удаа дараагийн дүрүүд морион саатаж, тахил ариусгалын судрууд бүтээжээ. XII жарны усан бар жил (1772) Энэтхэг газраас Рихе-Азала (Дансран Миёов) гэгч азар уг рашааныг шинжлэн болор, жоншны найрлагатай хэмээн айлдсан гэдэг. Уг рашаан нь энэ үеэс усан болор хэмээн нэрлэгдэх болжээ. Энэтхэг газрын энэ эрдэмтэн “*Шаргалжуутын рашаанд орох журам*” (“Сэрнёо лүнгийн Үүцан шүгвий рэмба”) хэмээх ном тууриулав. Энэ тухай “Гэгээнтний лавран гаргяам (гаржам)”⁴ гэдэг 42 ботийн 17-19 дүгээрт байдаг байв гэж Нүвлин дацангийн умзад, хожим аймгийн Орон нутгийг судлах музейн эрхлэгч агсан Лу.Юндэнбат ламтан тэмдэглэн үлдээсэн ажээ. Мөн энэ үеэс рашааны зүүн өмнөд талаас хүрээлэн хүүшлэх хунх нугалаа бүртгээ шинэсэн төгөлтэй их уулыг Жамсран сахиусны хор нөхөр болох Сайдон сахиусны нэрээр, голын урд талд рашааны зүүн хойт этгээдэд орших цагаан барс мэт цахир хадан хушууг Цогт охин тэнгэр буюу Балданхам бурханы алдраар, рашааны умард этгээдэд голын хойт талд байх зүрхэн өндөрлөгийг галын тэнгэр Дамжин Дорлиг бурханы алдраар нэрийдсэн нь манай үеийг хүртэл

³ Нутгийн түүх судлаач М.Ванчинсүрэн, Өлзийт сумын харьяат Янжмаа овогтой Осоржин (1916 онд төрсөн) нараас 1998, 1989 онд сонсож тэмдэглэсэн

⁴ Нууц нандин

уламжлагдан “*Лхамын хад*”, “*Сайдон*” уул, “*Дорлиг хайрхан*” (энэ гурван уулыг хамтатган товчоолсон алдар нь “Масадорсүм”) гэж нэрлэгддэг болсон байна. Энэ нь уг рашааныг гурван их догшин сахиусаар чандлан сахиулж, газар лусыг номхотгон дарж байхын бэлгэдэл болжээ. Түүний зохиосон номд рашаан хавийн ургамал амьтан, лус савдгийг дархлах ба цэвэр нямбай байлгахыг онцлон заасан байжээ. Ард олон ч рашаан усаа оточ Манла бурханы ариун орон лугаа зүйрлэн шүтэж ирсэн уламжлалтай. Рашаанд ирсэн хүмүүс рашааны дэг журам, ёс зарчмыг хатуу баримталж, рашааны шилээр унаа малтай хүн явдаггүй, рашаан дундуур зориуд тавьсан чулуун гишгүүрээс өөр газраар гишгэдэггүй байв. Ойр орчинд нь чанга дуугарах ба цай нүдэхийг ч хориглодог байсан учир уур нүдүүр ч цээртэй бөгөөд түнших доргиох зэргийг бүр их цээрлэдэг байжээ.

1823 онд Эрдэнэ бандида хутагтын шавь нарыг ерөнхийлэн захирах Шанзавын газраас тус рашааны хавь Арцтын амнаас Баяндаваа хүртэл газрыг дархан цаазтай болгосон нь рашаан усаа хайрлан хамгаалах, аргадан тахиx талаар эрт цагаас анхаарч ирснийг гэрчлэх нэгэн баримт юм. Урьдын цагт Дорлиг хайрхны урд бэлд дархан хүний чулуун дөш, чулуун уур, нүдүүр, зэрэг тавиатай байсан ба чулуун дөшийг Энэтхэг газрын Ганга мөрнөөс залж ирсэн гэдэг домогтой, түүнийг “*Дорлигийн дөш*” (Хавсралт 3 дахь гэрэл зургийг үзнэ үү) хэмээн нэрлэдэг байжээ. Энэ дөш чулуу эдүгээ Баянхонгор аймгийн музейд хадгалагдаж буй болно. “Дорлигийн дөш”-ийг хавар энэ нутагт хамгийн түрүүнд очсон айл (майхан)-д оруулан тавьдаг заншилтай байлаа. Рашаанд орох гэж ирсэн хүмүүс тэр чулуунд заавал дээж өргөдөг, тэр айлд өглөө бүр рашааны сан, тахилгын судар болох, Ламын гэгээн Лувсанцэвээнжавчогийн (1789-1855) номлосон “*Цагаан усан болорын ариутгал, тахилга сан*” уншиж тахидаг байжээ. Ламын гэгээний хийдээс жилд арав шахам удаа тусгай хувцас өмсгөл бүхий лам илгээж, эл рашаанд “*Дүлцингийн элс*” (*Дүлцин-са*) өргөн, адис жанлав оршоодог байсан гэх. Жил бүр Шарлин, Жүд, Гайс, Дэрэм хэмээх дөрвөн час дацан хариуцан дөрвөн уулын тахилга үйлдэж, дөрвөн уулын орой дээрх хийморь тугийг шинэтгэнэ. Мөн жилд нэг удаа 24 хүүхдийн хурим наадам, эхэс дээдэс, хүмүүсийн тай, заллага болж, Лхамын хадны орой дээр бишгүүр хөгжмөөр нянсан (уриа) өргөдөг уламжлалтай байжээ [34.2006.70].

Шаргалжуутын рашааны сан солчидыг Ламын гэгээний III дүрийн хувилгаан Лувсанцэвээнжавчог (1789-1846) ламтан бээр жүд хамба Лувсанцүлтэмийн хүсэлт тавьсны учирт айлдан зохиожээ. Тус сангийн сударт догшин сахиулсан тэнгэрүүд болох Балданлхам, Сайдон, Дамжан Дорлиг бурхадыг урин залж, гадаад, дотоод нууцын тахилыг өргөн рашаан үүнийг хүртэж буй төрөлхтнийг дөрвөн зуун дөрвөн язгуур өвчнөөс гэтэлгэн амгалан жаргалантай болгож, дээдийн ном дэлгэрч байхыг даатган ерөөжээ.

Ламын гэгээн шавь нь мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ Алтайн цаадах говийн Лиг, Цагаан голд арвай тариалж, гэгээн сан ба 8 дацангийн хурал номын хэрэгцээг хангаж байсан билээ. Ламын гэгээний IV дүрийн хувилгаан Лувсандамбацүлтэмийн (1847-1861)

найруулан зохиосон “Лиг хийгээд Цагаан гол, дэлгэр Баян цагаан уул⁵ тэргүүтэнд ариусгал тахил өргөх ёсон оршвой” хэмээх судрын хишиг даллагын хэсэгт:

Хөрөнгө цацагч тариалангийн орон газар үүнээ

Хутагт Энэтхэг орны арвай буудайн хишиг

Харь Төвд нутгийн арвай буудайн хишиг

Хар Хятад орны арвай буудайн хишиг

Шар Орос нутгийн арвай буудайн хишиг

Хор Монгол нутгийн арвай буудайн хишиг

Ирэгтүн ирэгтүн, арвайн хишиг ирэгтүн⁶ гэж тариалангийн уламжлалт бүс нутгаас алс зайдуу Алтайн цаад говьд тариалан эрхлэгч иргэдийн хүсэл эгээрлийг тусган шүлэглэсэн байна.

Тус шавийн ард иргэдийн амжиргааны гол эх үүсвэр болох таван хошуу мал, төрөл тус бүрээрээ өсөн ариажихын бэлгэдэл болгож, малчид, сүрэгчид өөрсдөө санаачлан онцлох содон шинж бүхий уул овоог сонгон тахиж байжээ. Өнөөгийн Өлзийт сумын нутагт гэхэд адуунаасаа түрүүлж яваа азаргын шинжтэй Хонгор азаргын нуруу, шавж байгаа буурын шинжтэй Сартах уул, баруун хойш хараад сүүлээ сөхөн агсарч байгаа сарлагийн бухын шинжтэй Баянгийн хүрэм, хониныхоо хойноос явж буй халзан хуцын шинжтэй Тэвшийн хүрэм (хамгийн зүүн захын мэл халзан судалтай тасархай ганц уул), ямаанаасаа түрүүлж яваа ухнын шинжтэй Зүүн шийр хайрхан зэрэг эцэг малын шинж бүрдсэн таван уулыг тахиж байсан байна.

1900 оны орчим Орог нуур нэг удаа ширгэхэд цагаан бор морьтой, ногоон торгон дээлтэй хар хүн, цагаан бор морьтой, ууж өмсгөлтэй 12 эхнэр хүн, жороо цагаан морь, ногоон торгон дээлээр ижилссэн 6 эрэгтэй, 6 эмэгтэй хүүхдээс бүрдсэн мөргөлчдийн цуваа нуурын шалыг 3 өдрийн турш нийт 9 удаа тойрч, мэгзэм уншиж, эхний хүн дүг⁷ барьж, нуурынхаа эзэн савдгийг дуудаж явсан гэнэ. Гэр гэртээ ирсний маргаашаас нь тэнгэр бүрхэж бороо шивэрч эхлээд нуурын ус цэлийтэл ирчихсэн байсан ажээ. Энэ тухай Баянхонгор аймгийн Богд сумын Цэлгэр багийн иргэн 80 настай Санжгяв овогтой Доржгявийн Долгор гуай 1986 онд хуучилсан болно. Долгор гуайн ээж тэр мөргөлийн улсуудын нэг байсан ажээ.

Лам, зайран, удган биш харин газар лусын өнгийг бэлгэдсэн ногоон торгон дээл, цагаан бор морь унасан хар хүн тахилгыг тэргүүлж, ногоон торгон дээл, ууж өмсгөлөөр гоёж, тэнгэрийн тахилгын цагаан бор морь хөлөглөсөн гоо үзэсгэлэнтэй 12 эхнэр, ногоон торгон дээл өмсөж, жороо цагаан морь унасан 12 хөвүүд охидоор, ус, лусыг дуудуулж байгаа нь⁸ гурван зууны өмнө Ламын гэгээнтний тогтоон төлөвшүүлсэн лус савдгийг

⁵ Уг сударт бичигдсэн Их Баян уул бол одоогийн Баянлиг сумын төвөөс баруун урагш 45-50 км зайд орших тахилга шүтлэгт уул юм. Их Баян уул эртний хүмүүсийн хадны зургийн цогц дурсгалаараа алдартай.

⁶ Лувсанданзанжалцан судлалын төвийн тэргүүн Д.Батболдын орчуулснаар авав.

⁷ Бурханы шашны ялгуулсны тэмдэг

⁸ “Ханчин хувилгааны нэрийг баригч (ламын гэгээн) бээр бичвэй” гэсэн тодотголтой тус шавийн нутаг дахь “Холбоолж” хэмээх улаан давст нуурын тахилгын сударт: “Очирт Ямандагын үлиггүй дээд хот

бурханы шашны үүднээс аргадах тахилгын зан үйл, улирах цагийн уртад улам бүр иргэний шинжийг олж, монгол нүүдэлчдийн ахуй зан үйлд уусан зохицож, хэлбэр, агуулгын хувьд баяжиж ирснийг илтгэн харуулж байна.

Уул овооны тахилга, тайлга нь өргөл тахил, уншлага дуудлага, хөгжим ая дан, эрийн гурван наадам, уртын дуу, сурын уухай, морь, бөхийн цол, уул хангайн магтаал зэрэг соёлын биет бус өвийн олон төрөл зүйлийг цогцоор агуулсан шашин, соёлын нийлэг зан үйл юм. Уул овоо тахих шашны зан үйл, иргэний зан үйлтэй ийнхүү нийлэгжин соёлын биет бус өвийн олон төрөл зүйлийг цогц байдлаар агуулдгаараа монголчуудын уламжлалт соёлыг язгуур шинжээр нь авч үлдэх чухал нөхцөл болдог бол, нөгөө талаас биет бус соёлын өвийн төрөл зүйлүүд эргээд тахилгын уламжлалт зан үйлийг баялаг сонирхолтой, онцлог өвөрмөц болгож, уламжлал шинэчлэлийн хэвийн зохистой үйл явцыг нөхцөлдүүлж өгдөг учраас өөр хоорондоо нягт уялдаатай, харилцан шүтэлцээтэй зүйл юм.

Байгальд хандах түүхэн уламжлал өөрчлөгдөж, байгалиа хайрлах уян зөөлөн сэтгэл, хатуу ширүүн зан авираар солигдсон өнөөгийн нөхцөлд уул овоо тахих уламжлалт зан үйлээр дамжуулан иргэд, олон нийтэд хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах, унаган байгалиа бишрэн дээдлэх хүмүүжил, ухамсрыг төлөвшүүлэхэд тахилгын уламжлалт зан үйл чухал нөлөөтэй болохыг илтгэлийнхээ эцэст цохон тэмдэглэе.

мандлаас очирт дээд Ролонма эх, түүний асар хувилгаан арван хоёр Данма охин тэнгэр, аясгалан зохист нуур үүнээ бодитой залрахтүн” гэж гардагтай өнгө, тоо, зүгийн утга бэлгэдлээр нийцэж байна.